



УВС АЙМГИЙН
ИРГЭДИЙН ТӨЛӨӨЛӨГЧДИЙН ХУРЛЫН
ТЭРГҮҮЛЭГЧДИЙН ТОГТООЛ

2018 оны 11 сарын 23 өдөр

Дугаар 133

Улаангом

"Биеийн тамир, спортыг хөгжүүлэх"
аймгийн дэд хөтөлбөр батлах тухай


Монгол Улсын Засаг захиргаа нутаг дэвсгэрийн нэгж, түүний удирдлагын тухай хуулийн 20 дугаар зүйлийн 20.1, 20.1.14 дэх заалт, Биеийн тамир, спортын тухай хуулийн 7 дугаар зүйлийн 7.1.1 дэх заалтыг тус тус үндэслэн ТОГТООХ нь:

Нэг. "Биеийн тамир, спортыг хөгжүүлэх" аймгийн дэд хөтөлбөрийг нэгдүгээр хавсралтаар, хэрэгжүүлэх арга хэмжээний төлөвлөгөөг хоёрдугаар хавсралтаар тус тус баталсугай.


Хоёр. Хөтөлбөрийг хэрэгжүүлэхэд шаардлагатай зардлыг жил бүрийн төсөвт тусган батлуулж, хэрэгжилтийг зохион байгуулж ажиллахыг аймгийн Засаг дарга /Д.Батсайхан/-д үүрэг болгосугай.

Гурав. Энэхүү тогтоолын хэрэгжилтэд хяналт тавьж ажиллахыг аймгийн ИТХ-ын Тэргүүлэгчдийн нарийн бичгийн дарга /Х.Дашзэвэг/-д даалгасугай.

ДАРГА



Э.НАСАНБАТ



"БИЕИЙН ТАМИР, СПОРТЫГ ХӨГЖҮҮЛЭХ" АЙМГИЙН ДЭД ХӨТӨЛБӨР
(2018-2022)

Агуулга

НЭГ.ЕРӨНХИЙ МЭДЭЭЛЭЛ

- 1.1 Тулгамдаж буй асуудал, өнөөгийн нөхцөл байдал
- 1.2 Хөтөлбөр боловсруулах үндэслэл, шаардлага

ХОЁР. ЗОРИЛГО, ЗОРИЛТУУД

- 2.1 Хөтөлбөрийн зорилго
- 2.2 Хөтөлбөрийн зорилтууд

ГУРАВ. ХӨТӨЛБӨРИЙГ ХЭРЭГЖҮҮЛЭХ ХУГАЦАА, ҮЙЛ АЖИЛЛАГАА

- 3.1 Хэрэгжүүлэх хугацаа
- 3.2 Үйл ажиллагааны чиглэл

ДӨРӨВ. ХӨТӨЛБӨРИЙН ҮР ДҮН, ШАЛГУУР ҮЗҮҮЛЭЛТ

- 4.1 Үр дүн
- 4.2 Шалгуур үзүүлэлт

ТАВ. ХӨТӨЛБӨРИЙН САНХҮҮЖИЛТ, ШААРДАГДАХ ХӨРӨНГӨ

- 5.1 Санхүүжилт
- 5.2 Шаардагдах хөрөнгө

ЗУРГАА. УДИРДЛАГА ЗОХИОН БАЙГУУЛАЛТ, ХЯНАЛТ-ШИНЖИЛГЭЭ, ҮНЭЛГЭЭ

- 6.1 Удирдлага, зохион байгуулалт
- 6.2 Хяналт шинжилгээ, үнэлгээ

Хавсралт : Хөтөлбөрийг хэрэгжүүлэх үйл ажиллагааны төлөвлөгөө

НЭГ. ЕРӨНХИЙ МЭДЭЭЛЭЛ

1.1 Өнөөгийн нөхцөл байдал, тулгамдаж буй асуудал

Өнөөгийн нөхцөл байдал.

Дэлхий дахинд биеийн тамир, спортын хөгжил, тамирчдын амжилт өдрөөс өдөрт дээшилж, биеийн тамир, спортоор хичээллэх шинэ хэрэгцээ шаардлагууд улам бүр нэмэгдсээр байгаа бөгөөд энэхүү хөгжилд хүрэх гол тулгуур нь бэлтгэл, сургалтыг шинжлэх ухааны үндэслэлтэй хийх, орчин нөхцлийг бий болгох өндөр зэрэглэлтэй тамирчид, дасгалжуулагчдыг бэлтгэх, урандаан тэмцээнд оролцох санхүүгийн эх үүсвэрийг бий болгох, нийтийн биеийн тамираар хичээллэх, хөдөлгөөний хомсдолоос урьдчилан сэргийлэх явдал юм.

Биеийн тамир, спортоор хичээллэгчдийн тоо

2017 оны хүн амын статистик тоогоор аймгийн хэмжээнд 10-59 насны 58098 иргэн байгаа бөгөөд судалгаагаар спортоор тогтмол хичээллэгчдийн тоо 14147 хүн байна. Энэ нь спортоор хичээллэх боломжтой иргэдийн 24 хувь юм.

Биеийн тамираар тогтмол хичээллэгчдийн тоо 4250 нь биеийн тамираар хичээллэх боломжтой иргэдийн 7,1 хувийг эзлэж байна.

ББХЧТТС: 2018 оны байдлаар аймгийн хэмжээнд сорилд хамрагдах 3-64 насны 72470 иргэн байна. Уг сорилд 63 байгууллага, ерөнхий боловсролын сургууль, цэцэрлэг болон 17 сумын 8754 хүн хамрагдсан бөгөөд насанд хүрэгчид 1869, 3-17 насны 6885 хүүхэд хамрагдсан байна. Сорилын хамрагдалтаар тооцож үзвэл уг 3-64 насны иргэдийн 20 хувийг хамруулсан байх шаардлагатай. Энэ нь аймгийн хэмжээнд хамрагдвал зохих 14494 хүний буюу 60,3% нь болж байна. / энэ нь 3-64 насны нийт хүн амын – 12,1% болж байна./

Биеийн тамирын мэргэжилтэй боловсон хүчин

ЕБ-ийн 24 сургуульд биеийн тамирын багш 73 ажиллаж байна. 18 нь буюу 24,6 хувь нь эмэгтэй. Эдгээрийн насны ангилалаар нь авч үзвэл 25-35 насны 30 буюу 41,6 хувь, 36-45 насны 30 буюу 41,6 хувь, 46-55 насны 10 буюу 13,9 хувь, 56-аас дээш насны 3 буюу 4,1 хувийг эзлэж байна.

Мэргэшлээр нь авч үзвэл багш дасгалжуулагч мэргэжлээр 23, биеийн тамир, эрүүл мэндийн багш мэргэжлээр 50 багш төгссөн. Нийт багш нарын МУБИС-ийг 18 багш, ҮБТДС-ийг 27, Шонхор БТДС-ийг 20, Ховд дахь багшийн сургуулийг 8 багш төгссөн. Тэргүүлэх зэрэгтэй 18, заах аргач зэрэгтэй 31 багш байна.

Цол зэргээр нь авч үзвэл Спортын мастер 10, Спортын дэд мастер 8, улсын шүүгч 3, бусад нь үндэсний бөхийн аймгийн цолтой болон, спортын 1-3 дугаар зэрэгтэй байна.

Гавьяа шагнал: Төрийн дээд одон медалиар шагнагдсан 4, АБТТА 13, БТСТА-20, Хүндэт жуух бичигтэй – 5 багш байна.

Биеийн тамир, спортын газарт спортын сургалт дасгалжуулалт хариуцсан 5 дасгалжуулагч, бусад клуб, дэвжээний багш дасгалжуулагч 1, нийт 16 дасгалжуулагч сургалт дасгалжуулалтыг зохион байгуулж байна.

Биеийн тамирын гадна талбай

Монгол улсын хамгийн анхны гадна талбай 1947 онд спортын холимог төрлийн зориулалттайгаар ашиглалтад оруулсан байна. Энэхүү талбай нь Увс аймгийн Улаангом сумын нутаг дэвсгэрт байсан.

Аймгийн хэмжээнд биеийн тамирын гадна талбай 33 байгаагийн 19 талбай ЕБС-ийн эзэмшилд, бусад нь төрийн болон хувь иргэний мэдэлд байна.

Гадна талбайн ашиглалтад орсон оноор нь тооцож үзвэл 1945-2010 онд ашиглалтанд орсон 12, 2010-2017 онд 13 гадна талбай ашиглалтанд орсон.

Биеийн тамирын заал

Аймгийн хэмжээнд Биеийн тамир, спортын газрын зориулалтаар ашиглагдаж байгаа нийт 38 спортын барилга байгууламж байгаа ба байгууллага, хувь хүний эзэмшилд 7 спорт заал, ЕБС-ын 24 сургуульд том жижиг талбай бүхий 27 спорт заал тус тус байна.

Дугуйлан секц

Аймгийн хэмжээнд ЕБС-ийн 24 сургуульд 73 багш спортын 12 төрөлд спортын сонгон суралцах секц хичээллүүлж, түүнд 3356 сурагч хамрагдаж байна. Үүнээс 1400 нь охид байна. Секц дугуйланд хамрагдаж байгаа сурагчдаас 6-8 насны 337, 9-11 насны 731, 12-15 насны 1179, 16-17 насны 814 сурагч байна.

1.2 Хөтөлбөр боловсруулах үндэслэл, шаардлага

Биеийн тамир, спортыг хөгжүүлэх таатай орчныг бүрдүүлэх, материаллаг бааз, спортын хэрэгслийн хангамжийг сайжруулах, иргэдийг нийтийн биеийн тамир, спортоор тогтмол хичээллэх дадал зуршилтай болгох, биеийн тамир, спортын мэргэжлийн байгууллага болон спортын холбоод, сум аж ахуйн нэгж, байгууллагуудын хамтын ажиллагааг өргөжүүлэх, багш дасгалжуулагчдын мэдлэг, ур чадварыг сайжруулах, чадавхижуулах зэрэг цаашид хэрэгжүүлэх арга хэмжээг нарийвчлан тодорхойлсон аймгийн дэд хөтөлбөр боловсруулж хэрэгжүүлэх шаардлага бий болж байна.

Биеийн тамир, спортын тухай шинэчилсэн хууль батлагдаж, төрийн захиргааны төв байгууллагын бүтэц, зохион байгуулалт өөрчлөгдсөн, бодлогын баримт бичигт биеийн тамир, спортыг хөгжүүлэх талаар дэвшүүлсэн зорилтыг хэрэгжүүлэх спортын амжилтыг ахиулах зорилгоор уг хөтөлбөрийг боловсруулав.

Хөтөлбөрийг боловсруулахад үндэслэсэн эрх зүйн эх сурвалж:

1. Монгол улсын Засгийн газрын болон Аймгийн Засаг даргын 2016-2020 оны үйл ажиллагааны мөрийн хөтөлбөр
2. УИХ-ын 2009 оны 95 тоот тогтоол "Биеийн тамир, спортыг хөгжүүлэх талаар төрөөс баримтлах бодлого
3. Монгол улсын Засгийн газрын 2011 оны 32 тоот цогц хөтөлбөр
4. Монгол улсын Засгийн газрын 2016 оны 145 тоот тогтоол /"Азийн хүүхдүүд 2020" хөтөлбөр/.

Энэхүү хөтөлбөр нь нийтийн биеийн тамир, нийтлэг спортын төрлүүд, өндөр амжилт үзүүлж буй спортын төрөл, спортыг хөгжүүлэх талаар төрийн болон төрийн бус байгууллагаас хэрэгжүүлж буй бодлого, чиглэл, арга хэмжээний тодорхой чиглэлүүдийг багтаан хэрэгжүүлэх гол баримт бичиг мөн.

ХОЁР. ЗОРИЛГО, ЗОРИЛТУУД

2.1 Хөтөлбөрийн зорилго:

Нийтийн биеийн тамир, спортыг хүн амын өдөр тутмын хэрэглээ, амьдралын хэв маяг, дадал, зан үйл болгох, дундаж, наслалтыг нэмэгдүүлж, спортыг олон улсын жишигт хүргэн хөгжүүлэхэд хөтөлбөрийн зорилго оршино.

2.2 Хөтөлбөрийн зорилт

Хөтөлбөрийн зорилгыг хэрэгжүүлэх хүрээнд дараах 4 зорилгыг хэрэгжүүлнэ.

- Зорилт 1. Нийтийн биеийн тамирын үйл ажиллагааг эрчимжүүлэх
- Зорилт 2. Өсвөрийн шигшээ багийн сургалт дасгалжуулалтыг хөгжүүлэх
- Зорилт 3. Хүний нөөц, багш дасгалжуулагчдыг чадавхижуулах, мэргэшүүлэх
- Зорилт 4. Спортын хэрэглэл материал, тоног төхөөрөмжийг нэмэгдүүлэх

ГУРАВ. ХӨТӨЛБӨРИЙГ ХЭРЭГЖҮҮЛЭХ ХУГАЦАА, ҮЙЛ АЖИЛЛАГАА

3.1 Хэрэгжүүлэх хугацаа

Хөтөлбөрийг 2019-2022 он хүртэл хэрэгжүүлнэ.

3.2 Үйл ажиллагааны чиглэл

Зорилт 1. Нийтийн биеийн тамирын үйл ажиллагааг эрчимжүүлэх

Энэ зорилт нь дараах чиглэлийн үйл ажиллагаагаар хэрэгжинэ.

Иргэдийн оршин суугаа газарт биеийн тамир, спортоор бие даан хичээллэх, иргэдийн дунд биеийн тамир-эрүүл мэнд нийтийн биеийн тамир, спортын арга хэмжээнүүдийг тогтмол зохион байгуулах

- 3.2.1.1 Иргэд, олон нийтийн дунд зохион байгуулах нийтийн биеийн тамир,спортын уралдаан тэмцээнийг олшруулж, мэдээлэл сургалт сурталчилгааг идэвхжүүлж, материаллаг баазыг нэмэгдүүлэх.
- 3.2.1.2 Хүн амын дунд явуулах сорилын үйл ажиллагааг эрчимжүүлэх,үр дүн, үнэлгээг жил бүр тайлагнах,
- 3.2.1.3 Биеийн тамирын арга зүйч,идэвхтэн нарыг бэлтгэх ажлыг зохион байгуулах.
- 3.2.1.4 Иргэдийн дунд эрүүл, зөв амьдралын хэв маягийг биеийн тамир, спортоор дамжуулан төлөвшүүлэх
- 3.2.1.5 Олон нийтийн мэдээллийн хэрэгслээр дамжуулан эрүүл амьдралын хэв маяг болон биеийн тамир, спортын арга хэмжээг сурталчлах, нийт иргэдийг идэвхжүүлэх сургалт, сурталчилгааг эрчимжүүлэх

Хүрэх үр дүн:

- Иргэдийн бие бялдраа чийрэгжүүлэх, эрүүл амьдралыг хэвшүүлэх талаарх хандлага өөрчлөгдөнө.
- Иргэдийн нас, биеийн онцлогт тохирсон спортын арга хэмжээнд тогтмол хамруулж, оролцогч иргэдийн тоо нэмэгдсэн байна.

Зорилт 2. Өсвөрийн шигшээ багийн тамирчдын сургалт дасгалжуулалтыг хөгжүүлэх.

Хэрэгжүүлэх үйл ажиллагаа

- 3.2.2.1 Өсвөрийн шигшээ баг, ерөнхий боловсролын сургууль, спортын клубүүдэд зохион байгуулагдаж буй спортын секц дугуйлан,сургалт дасгалжуулалтыг чанартай явуулж, өсвөр үеийнхэний бие бялдрын хөгжил,хүмүүжилд ахиц гарган ажиллах.
- 3.2.2.2 Биеийн тамир,спортын төрөлжсөн сургалттай дунд сургууль байгуулах, хөгжүүлэх
- 3.2.2.3 Спортын бэлтгэл, сургалт-дасгалжуулалтын орчин нөхцлийг сайжруулах
- 3.2.2.4 Өсвөрийн тамирчдын сургалт-дасгалжуулалт,уралдаан тэмцээний төлөвлөгөөг боловсронгуй болгох
- 3.2.2.5 Өсвөрийн тамирчдыг "Хяналтын карттай" болгох.
- 3.2.2.6 Олимпийн хөдөлгөөн болон хүүхдийн спорт, өсвөрийн тамирчдын үйл ажиллагааг өргөнөөр сурталчлах
- 3.2.2.7 Олимпийн соёл, боловсрол түүх ба хүмүүжлийн чиглэлээр үйл ажиллагаа явуулдаг төрийн бус байгууллагатай хамтран ажиллах.
- 3.2.2.8 Спортын холбоодын үйл ажиллагаанд дэмжлэг үзүүлэх, өсвөрийн шигшээ багийг спортын холбоодын дэргэд хичээллүүлэх.

Хүрэх үр дүн:

- Өсвөрийн тамирчдын спортын амжилт,үр чадвар дээшилсэн байна.
- Өсвөрийн тамирчид тэсвэр тэвчээртэй болох, хүмүүжлийн зэрэг хандлагад суралцах

Зорилт 3 Хүний нөөц,багш дасгалжуулагчдыг чадавхижуулах,мэргэшүүлэх

Хэрэгжүүлэх үйл ажиллагаа

- 3.2.3.1 Спортын салбарын хүний нөөцийн судалгааг гаргах, дутагдалтай спортын төрлийн багш дасгалжуулагчдыг бэлтгэх, мэргэжил дээшлүүлэх асуудлыг шийдвэрлүүлэх.
- 3.2.3.2 Дасгалжуулагчдыг мэргэжил дээшлүүлэх, зэрэглэл тогтоох сургалтуудад үе шаттайгаар хамруулах.
- 3.2.3.3 Өндөр зэрэглэл бүхий дасгалжуулагчдыг урьж ирүүлэх, гэрээгээр ажиллуулах асуудлыг судлан шийдвэрлэх.
- 3.2.3.4 Багш дасгалжуулагчдыг судалгааны арга зүйд сургах, илтгэл эрдэм шинжилгээний хурлуудыг зохион байгуулах

Хүрэх үр дүн:

- Спортын салбарын хүний нөөцийн зохистой бодлогыг хэрэгжүүлсэн байна.
- Багш дасгалжуулагчдыг ажлын байран дээр нь сургаж хөгжүүлэх
- Багш дасгалжуулагчдын мэргэжлийн болон шинжлэх ухааны мэдлэг, чадвар сайжирсан байна.

Зорилт 4: Спортын хэрэглэл материал, тоног төхөөрөмжийг сайжруулах.

Хэрэгжүүлэх үйл ажиллагаа

- 3.2.4.1. ЕБС-ийн биеийн тамирын хичээлийн материаллаг бааз, хичээллэх орчин нөхцлийн талаар судалгаа хийх, түвшин тогтоох.
- 3.2.4.2. Өсвөрийн шигшээ багийн тамирчдын бэлтгэл сургалтаа зохион байгуулах тоног төхөөрөмж, хэрэглэл материалыг үе шаттайгаар шинэчлэх.
- 3.2.4.3 Бөхийн "Шандас" клубыг их засварт оруулах, өргөжүүлэх

Хүрэх үр дүн:

- Өсвөр үеийнхэний биеийн тамир, спортоор хичээллэх таатай нөхцөл бүрдсэн байна.
- Тамирчдын бэлтгэл сургалтаа хийхэд шаардлагатай спортын хэрэглэл материалаар хангагдсан байна.

ДӨРӨВ. ХӨТӨЛБӨРИЙН ШАЛГУУР ҮЗҮҮЛЭЛТҮҮД

4.1 ҮР ДҮН: Хөтөлбөрийг хэрэгжүүлснээр дараах үр дүнд хүрнэ.

- 4.1.1 Биеийн тамираар хичээллэх орчин нөхцөл бүрдэж, иргэдийн бие бялдрын боловсрол нэмэгдэж, биеийн тамираар хичээллэгч, эрүүл мэндээ бэхжүүлэгч иргэдийн тоо өсөж, халдварт бус өвчний өмчлөл буурч, хүн амын дундаж наслалт нэмэгдэнэ.
- 4.1.2 ЕБС-ийн биеийн тамирын хичээлийн үр нөлөө дээшилж, өсвөр үеийнхний бие бялдрын өсөлт нэмэгдэнэ.
- 4.1.3 Хүн амын бие бялдрын хөгжил, чийрэгжилтийн түвшин тогтоох сорилт хамрагдагчдын тоо нэмэгдэж, мэдээллийн сан бүрдүүлэлт сайжирсан байна.
- 4.1.4 Тив, дэлхий, олимпийн тэмцээнд оролцох тамирчдын тоо өсөн нэмэгдэж, тамирчдын амжилт дээшилнэ.
- 4.1.5 Багш дасгалжуулагчид, боловсон хүчний ур чадвар нэмэгдэнэ.

- 4.1.6 Спортын төрлүүдээр зохион байгуулагдах уралдаан тэмцээний тоо нэмэгдэж өсвөрийн тамирчдын ур чадвар, амжилт нэмэгдсэн байна.
- 4.1.7 Спортын холбоодын үйл ажиллагаа жигдэрч, бие даасан байдал хангагдана.
- 4.1.8 Хүүхэд өсвөр үеийнхэнд үндэсний спорт, ардын уламжлалт тоглоом наадгайг өвлүүлэх, сурталчлах ажил тасралтгүй явагдаж, үндэсний уламжлал, ёс заншил уламжлагдана.
- 4.1.9 Сум бүр спортын заал танхимтай, хэрэглэл материал, тоног төхөөрөмжөөр хангагдах нөхцөл бүрдэнэ.
- 4.1.10 Иргэдийн биеийн тамир, спортоор хичээллэх, алхалт, гүйлтийн зам талбайтай болж иргэдийн чөлөөт цагаа өнгөрөөх, биеийн тамирын дасгал хөдөлгөөнөөр хичээллэх боломж бүрдэнэ.
- 4.1.11 Сум бүр биеийн тамирын орон тооны арга зүйчтэй болсон байна.

4.2 Хөтөлбөрийн үр дүнг дараах шалгуур үзүүлэлтээр үнэлнэ.

№	Шалгуур үзүүлэлт	Хэмжих нэгж	Суурь түвшин (2018)	Үзүүлэлт	Зорилт түвшин (2021)	Үзүүлэлт	Мэдээллийн эх сурвалж	Хэрэгжүүлэх байгууллагууд
1	ББТТС-д хамрагдсан иргэдийн тоо	Тоо	2017	8700	2022	14500	Статистик тоо бүртгэлд үндэслэн	БСУГ,ЭМГ,сумдын ЗДТГ,нийт байгууллагууд
2	Хүн амын бие бялдрын хөгжил чийрэгжилтийн түвшин тогтоох сорилд хамрагдагсадын хувь	Хувь	2017	12,1	2022	20	Статистик тоо бүртгэлд үндэслэн	БСУГ,ЭМГ,сумдын ЗДТГ, нийт байгууллагууд
3	Спортоор тогтмол хичээллэгчдийн хувь	Тоо	2017	24,0	2022	28,0	Статистик тоо бүртгэлд үндэслэн	ЕБС, Спортын холбоод, чийрэгжүүлэлтийн клуб
4	Биеийн тамираар тогтмол хичээллэгчдийн хувь	Хувь	2017	7,1	2022	11	Статистик тоо бүртгэлд үндэслэн	ЕБС, Спортын холбоод, чийрэгжүүлэлтийн клуб
5	Биеийн тамир, чийрэгжүүлэлтийн орон тооны	Тоо	2017	1	2022	19	БТС-ын тухай хуулийг	Сумдын ЗДТГ

	арга зүйч						үндэслэн	
6	Биеийн тамир, спортын заал	Тоо	2017	38	2022	41	Статистик тоо бүртгэлд үндэслэн	Хөгжлийн бэрхшээлтэй иргэдийн ТББ
7	Биеийн тамир, спортын ил талбай	Тоо	2017	33	2022	35	Статистик тоо бүртгэлд үндэслэн	БСУГ,ЭМГ,сумдын ЗДТГ
8	Байгууллага, аж ахуйн нэгжийн дэргэдэх биеийн тамирын хамтлаг	Тоо	2017	2	2022	10	Статистик тоо бүртгэлд үндэслэн	БСУГ,ЭМГ,сумдын ЗДТГ
9	Тив,дэлхий,ОУ-ын тэмцээнд оролцох тамирчдын тоо	Тоо	2017	20	2022	30	Статистик тоо бүртгэлд үндэслэн	БСУГ,ЭМГ,сумдын ЗДТГ
10	Тив,дэлхий,ОУ-ын тэмцээнээс хүртэх медалийн тоо	Тоо	2017	16	2022	20	Статистик тоо бүртгэлд үндэслэн	БСУГ,ЭМГ,сумдын ЗДТГ
11	Сорилд хамрагдсан иргэдийн АВ-ийн эзлэх хувь	Хувь	2017	34,4	2022	38,4	Статистик тоо бүртгэлд үндэслэн	БСУГ,ЭМГ,сумдын ЗДТГ

ТАВ. ХӨТӨЛБӨРИЙН САНХҮҮЖИЛТ, ШААРДАГДАХ ХӨРӨНГӨ

5.1 Санхүүжилт

Хөтөлбөрийн санхүүжилт дараах эх үүсвэрээс бүрдэнэ.

- Улсын болон орон нутгийн төсвөөс хуваарилсан хөрөнгө
- Олон улсын байгууллага, төсөл хөтөлбөрийн санхүүжилт
- Тухайн салбарын төсөв
- Бусад эх үүсвэр

5.2 Шаардагдах хөрөнгө

/Хавсралт 3/

ЗУРГАА. УДИРДЛАГА,ЗОХИОН БАЙГУУЛАЛТ,ХЯНАЛТ-ШИНЖИЛГЭЭ, ҮНЭЛГЭЭ

6.1 Удирдлага, зохион байгуулалт

- Хөтөлбөрийн хэрэгжилтийг аймгийн хэмжээнд зохион байгуулах, уялдуулан зохицуулах, хяналт тавих үүргийг аймгийн Засаг даргын тамгын газрын Нийгмийн бодлогын хэлтэс гүйцэтгэнэ. Аймгийн Засаг дарга нь сумын болон байгууллагын дарга нартай байгуулах үр дүнгийн гэрээнд Биеийн тамир, спортыг хөгжүүлэх дэд хөтөлбөрийг хэрэгжүүлэх ажлыг тусгана.
- Аймаг, сумын жил бүрийн эдийн засаг, нийгмийг хөгжүүлэх үндсэн чиглэлд дэд хөтөлбөрийг хэрэгжүүлэх үйл ажиллагаа зардлыг тусгаж Иргэдийн төлөөлөгчдийн хурлаар баталгаажуулна.
- Энэхүү ажлыг сумын Засаг дарга удирдан зохион байгуулж дэд хөтөлбөрийг хэрэгжүүлэх ажлын хүрээнд хийсэн ажлын тайланг Биеийн тамир, спортын газарт ирүүлнэ.

6.2 Хяналт, шинжилгээ, үнэлгээ

Дэд хөтөлбөрийн хэрэгжилтийн үр дүнгийн үнэлгээг аймгийн Засаг даргын тамгын газар хийнэ.

Аймгийн Засаг дарга нь шаардагдах төсөв хөрөнгийг аймгийн эдийн засаг, нийгмийг хөгжүүлэх жил бүрийн үндсэн чиглэлд тусгаж, үр дүнг аймгийн ИТХ-ын Тэргүүлэгчдэд тайлагнана.

Дэд хөтөлбөрийн хүрээнд зохион байгуулагдаж байгаа ажлуудыг аймгийн ЗДТГ-ын цахим хуудсаар олон нийтэд тогтмол сурталчилж мэдээлнэ.

Аймгийн ИТХ-ын Тэргүүлэгчдийн
 2018 оны 11 сарын 23 - ний өдрийн 1/32
 дугаар тогтоолын хоёрдугаар хавсралт

Биеийн тамир, спортыг хөгжүүлэх аймгийн дэд
 хөтөлбөрийг хэрэгжүүлэх ажлын төлөвлөгөө

№	Тийл амжилтаа	Бүтээгдэх үүн	Шалгуур үзүүлэлт	Арга-жилийн г хариуцах байгууллага	Хамтран хэрэгжүүлэх байгууллага	Хэрэгж их хугацаа
	Зорилго	Нийтийн биеийн тамир, спортыг хүн-амын өдөр тутмын хэрэглээ, амьдралын хэв маяг, дадал, зан үйл болгох, дундаж, наслалтыг нэмэгдүүлж, спортыг олон улсын жишигт хүргэн хөгжүүлэхэд хөтөлбөрийн зорилго оршино.				
	Үр дүн	<ol style="list-style-type: none"> 1. Биеийн тамир, спортоор хичээллэгчдийн тоог нэмэгдсэн байна. 2. Иргэдийн дунд зохион байгуулах биеийн тамирын арга хэмжээ нэмэгдэнэ. 3. Ахмад настан, хөгжлийн бэрхшээлтэй иргэдийн биеийн тамирын арга хэмжээнд оролцох идэвх оролцоо нэмэгдэж, биеийн тамир, спортоор хичээллэх орчин нөхцөл бүрдсэн байна. 4. Хөдөлгөөний хомсдоллоос үүдэлтэй өвчлөл буурсан байна. 				
1.1 Нийтийн биеийн тамирын үйл ажиллагааг эрчимжүүлэх						
1	Байгууллага бүр ажлын байран дахь, ЕБС –иуд АБ-ийн их завсарлагаанаар дасгал хөдөлгөөнийг хийж хэвших	Дасгал хийж хэвшүүлсэн сургууль 15-20 Байгууллага -20	Дасгал хийж хэвшүүлсэн сургууль 15-20 Байгууллага -20	БТСГ	БСУГ,ЭМГ байгууллага, аж ахуйн нэгж	2019-2020
2	МУЕ-ийн зарлигийн дагуу "Хүн амын бие бялдрын хөгжил чийрэгжилтийн түвшин тогтоох сорил"-ыг зохион байгуулж үр дүнг тайлагнах.	Сорил	38.4 хувийг хамруулах	БТСГ	БСУГ,ЭМГ	Жил бүр
3	Нийтийн биеийн тамирыг хөгжүүлэх чиглэлээр	Спортын	10 удаагийн	БТСГ	Сумдын	2019-

	нийт иргэдийг хамарсан өглөөний гүйлт дасгал, явган аялал, нийтийн бүжиг арга хэмжээг тогтмол зохион байгуулах, дэмжлэг үзүүлэх	арга хэмжээ	арга хэмжээнд 1500-2000 хүн хамруулна.		ЗДТГ	2022
4	Төрийн байгууллагуудын дунд таргалалтаас урьдчилан сэргийлэх зорилгоор болзолт уралдааныг үе шаттайгаар зохион байгуулах.	Болзолт уралдаан	ТАХ 500-600 хүн хамруулна.	БТСГ	ЭМГ	2019-2022
5	Ахмад настан, хөгжлийн бэрхшээлтэй иргэдийн биеийн тамир, спортоор хичээллэхэд нь дэмжлэг үзүүлэх.	дэмжлэг	60-70 хүнийг тогтмол хамруулна	БТСГ	Ахмадын хороо, ХБИ-ийн холбоо	2019-2022
6	Нийтийн биеийн тамир, спортыг сурталчлах, мэдээлэл, арга зүйн зөвлөмж, зөвлөгөө өгөх ажлыг тогтмол зохион байгуулах	Мэдээлэл зөвлөгөө	Жилд 3 сум, 15-20 байгууллага	БТСГ	Сумдын ЗДТГ	2019-2022
7	Биеийн тамир, спортыг дэмжигч байгууллага, хамт олныг жил бүр шалгаруулдаг журам боловсруулах, хэрэгжүүлэх	Журам	Болзолт уралдаан	БТСГ	ЭМГ, байгууллага	2019-2022
8	Улаангом сумын багийн иргэдийн Спортын наадамьг 2 жил тутам зохион байгуулах	Заавар, удирдамж	Оролцсон иргэдийн тоо	БТСГ	Улаангом сумын ЗДТГ	2019-2022
9	Төрийн байгууллагын зарим ажил үйлчилгээг төрийн бус байгууллагаар гүйцэтгүүлэх /спортын уралдаан тэмцээнийг спортын холбоодтой хамтран зохион байгуулах/	Уралдаан тэмцээн	Оролцсон иргэдийн тоо	БТСГ	Спортын холбоод	2019-2022
10	Багийн иргэдийн дунд "Спортын бага наадам"-ыг жил тутам зохион байгуулах	Бага наадам	Оролцсон иргэдийн тоо	БТСГ	Спортын холбоод	2019-2022
11	Оюутны спортын наадмыг 4 жил тутам зохион байгуулах.	Бага наадам	Оролцсон тамирчдын тоо	БТСГ	Спортын холбоод	2021
12	Үндэсний спортын наадмыг 4 жилд нэг удаа зохион байгуулах	Бага наадам	Оролцсон тамирчдын тоо	БТСГ	Спортын холбоод	2022
13	"Өртөөт марафон" арга хэмжээг зохион байгуулах.	Бага наадам	Оролцсон иргэдийн тоо	БТСГ	ЭМГ, Сумын ЗДТГ	2019

14	Софт волейбол, гранд гольф, ширээний шагайн төрлөөр аймгийн АШТ-ийг насны ангилалаар зохион байгуулах.	Уралдаан тэмцээн	зохион байгуулсан тэмцээний тоо	БТСГ	Спортын холбоо	2019
15	Ахмад мастеруудын холбооны үйл ажиллагааг идэвхжүүлэх, туршлага арга зүйг түгээн дэлгэрүүлэх	Үйл ажиллагаа	Зохион байгуулсан үйл ажиллагааны тоо	БТСГ	Ахмад мастеруудын холбоо	2019-2022
1.2 Өсвөрийн шигшээ багийн тамирчдын сургалт дасгалжуулалтыг сайжруулах зорилтын хүрээнд						
16	Бөхийн 3 төрлөөр өсвөрийн тамирчдын дунд ЛIG-ийн тэмцээн зохион байгуулах. /улирал бүр/	Уралдаан тэмцээн	9 удаа зохион байгуулж 1200-1500 тамирчин хамруулна	БТСГ	Спортын холбоод, БСУГ	2019-2020
17	Аймгийн хүүхдийн спортын "Бага олимп"-ийг зохион байгуулах	Бага олимп	Спортын 17 төрөлд 1500-аас доошгүй тамирчин хамруулна	БТСГ	БСУГ	2019
18	Хөрш зэргэлдээ ОХУ-ны Тува, Халимаг улсын БТС-ын байгууллагатай хамтран ажиллаж өсвөрийн тамирчидтай хамтарсан бэлтгэл сургалт зохион байгуулах.	Бэлтгэл сургуулилт	Жилдээ 2-3 спортын төрлөөр 10-аас доошгүй тамирчид	БТСГ	Аймгийн ЗДТГ	2019-2022
19	Биеийн тамир, спортын төрөлжсөн сургалттай дунд сургуулийн үйл ажиллагааг дэмжин ажиллах	Дэмжлэг		БТСГ	Аймгийн ЗДТГ, ЕБ-ийн 5 сургууль	2018-2020
1.3 Хүний нөөц, багш дасгалжуулагчдыг чадавхижуулах, мэргэшүүлэх						
20	Спортын төрөл тус бүрт багш дасгалжуулагчдыг чадваржуулах сургалтыг зохион байгуулж дотоодын болон хөрш зэргэлдээ орнуудад сургалтанд хамруулах, давтан сургах..	Сургалт	Спортын 5-аас доошгүй төрлөөр багш,	БТСГ	Спортын холбоод	2019-2020

				дасгалжуулагчдийг хамруулсан байна.	БТСГ	БТСГ,спортын холбоод	2019-2022
21	Өндөр зэрэглэлийн ур чадвартай дасгалжуулагчдыг урьж ирүүлэн сургалт зохион байгуулах.	Сургалт	Сургалт	Спортын 2 төрөлд 40-50 багшийг хамруулна.	БТСГ	БТСГ,спортын холбоод	2019-2022
22	Багш дасгалжуулагчдын дунд судалгаа, эрдэм шинжилгээ,илтгэлийн уралдааныг тогтмол зохион байгуулах.	Судалгаа, илтгэл	Судалгаа, илтгэл	Жилдээ 1-2 удаа	БТСГ	БСУГ,ЭМГ	2019-2022
23	Багш дасгалжуулагчдыг мэргэжлийн гарын авлага, материалаар хангах.	Гарын авлага	Гарын авлага	нийлүүлсэн ном, хэрэглэгдэхүүний тоо	БТСГ	БСУГ,ЭМГ	2019-2022
24	БСУГ-тай хамтран биеийн тамирын багш, дасгалжуулагч солилцоо арга хэмжээг ЕБС-д зохион байгуулах.	Багш солилцоо хөтөлбөр	Багш солилцоо хөтөлбөр	жилд 5 –аас доошгүй удаа зохион байгуулах	БТСГ	БСУГ	2019-2022
25	Дасгалжуулагчдад зэрэглэл тогтоох аргачлалыг зохион байгуулах	аттестатчилаг	аттестатчилаг	аттестатчлал зохион байгуулагдсан байх	БТСГ	БТСГ шигшээ баг	2019-2020
26	Арга зүйчдэд мэргэжлийн зэрэглэл тогтоох.	Зэрэглэл	Зэрэглэл	зэрэглэл тогтоосон байх	БТСГ	БТСГ,шигшээ баг	2019-2020
27	Орон тооны спортын эмчтэй болох.	Эмч	Эмч	эмчтэй болсон байх	БТСГ	ЭМГ	2019
1.4. Спортын хэрэглэл материал,тоног төхөөрөмжийг сайжруулах зорилтын хүрээнд:							
28	Тамирчдын бэлтгэлийн баазтай болох.	Бэлтгэлийн бааз	Бэлтгэлийн бааз	Зураг төсөв хийлгэх	БТСГ	Аймгийн ЗДТГ	2019-2022
29	Өсвөрийн тамирчдын бэлтгэл сургалтаа зохион байгуулах хэрэглэл материалтай болох.	Хэрэглэл материал	Хэрэглэл материал	5 төрөлд	БТСГ	Аймгийн ЗДТГ	2019-2022
30	Бөхийн Шандас клубт их засвар хийх	засвар	засвар	Төсвийг батлуулах	БТСГ	Аймгийн ЗДТГ	2019

31	Сум бүрт биеийн тамирын гадна талбайтай болох	Гадна талбай	Аймгийн ИТХ-ын тэргүүлэгчид	БТСГ	Сумдын ЗДТГ	2019-2022
32	Хөгжлийн бэрхшээлтэй иргэдийн спортыг дэмжих /хэрэглэл материал,уралдаан тэмцээн/	дэмжлэг	1-2 төрөлд	БТСГ	ХБИ-ийн ТББ	2019-2020
33	Сумдад спортын заал барих	Спорт заал	Улсын төсөвт суулгах	ХАА	Барилгын компаниуд	2019-2020